

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/60/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Аудитор: С.Батсуурь  
Утас: 70453799, Цахим хаяг: Batsuuris@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ЗАВХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Т.ТАМИР ТАНАА

2023.02.24 № УВА-2023/60/НА-СТА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200500581

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>48,832,815.51</u></b>	<b><u>44,262,105.78</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.00	663.78
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	663.78
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	48,832,815.51	44,261,442.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	48,832,815.51	40,264,109.00
35410	Бичиг хэргийн материал	2,730,161.50	2,528,300.00
35420	Аж ахуйн материал	29,033,239.00	24,703,089.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,370,000.00	1,170,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,016,191.01	0.00
35470	Бусад хангамжийн материал	13,683,224.00	11,862,720.00
35600	Мал амьтад	0.00	3,997,333.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>828,743,434.94</u></b>	<b><u>935,789,855.28</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	828,743,434.94	935,789,855.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	806,892,254.94	913,938,675.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	634,102,548.54	708,902,476.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(113,754,602.91)	(148,186,249.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,774,700.00	109,379,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,083,600.08)	(38,132,275.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	157,916,187.22	178,702,855.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,417,903.31)	(107,966,150.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,653,550.00	42,823,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,924,884.15)	(27,869,717.63)
39214	Бусад үндсэн хөрөнгө	523,894,576.00	652,415,114.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(350,268,316.37)	(456,130,627.57)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	21,851,180.00	21,851,180.00
39301	Програм хангамж	1,995,000.00	1,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,995,000.00)	(1,995,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,851,180.00	21,851,180.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>877,576,250.45</u></b>	<b><u>980,051,961.06</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>877,576,250.45</u></b>	<b><u>980,051,961.06</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	877,576,250.45	980,051,961.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,247,326.99	470,247,326.99
51101	Өмч: - төрийн	470,247,326.99	470,247,326.99
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	152,632,648.81	255,108,359.42
51210	Өмнөх үеийн үр дүн	(22,214,876.84)	(22,214,876.84)
51220	Тайлант үеийн үр дүн	174,847,525.65	277,323,236.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	254,696,274.65	254,696,274.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>877,576,250.45</u></b>	<b><u>980,051,961.06</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>745,593,517.50</b>	<b>728,093,102.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>178,925,851.50</b>	<b>239,173,564.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	175,345,851.50	239,173,564.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,345,851.50	239,173,564.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	175,345,851.50	234,358,029.40
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	3,580,000.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/	3,580,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>566,667,666.00</b>	<b>488,919,538.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	159,965,066.00	44,545,538.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	159,965,066.00	44,545,538.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>406,702,600.00</b>	<b>444,374,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	406,702,600.00	444,374,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>578,250,922.89</b>	<b>625,500,391.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>496,376,151.89</b>	<b>625,500,391.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>453,510,908.20</b>	<b>579,663,444.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>232,799,896.68</b>	<b>242,756,177.97</b>
210101	Үндсэн цалин	206,020,270.68	196,552,121.89
210102	Нэмэгдэл	0.00	33,322,804.68
210104	Урамшуулал	0.00	11,201,251.40
210105	Гэрээт ажлын хөлс	26,779,626.00	1,680,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,137,053.96</b>	<b>30,335,713.44</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,856,991.30	20,654,440.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,325,156.91	2,429,934.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,860,125.13	1,933,867.24
210204	Ажилгүйдлийн даатгал	463,162.11	483,466.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,631,618.51	4,834,004.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,197,827.67</b>	<b>37,171,049.38</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,509,047.67	3,673,481.38
210302	Түлш, халаалт	28,688,780.00	33,497,568.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,207,359.99</b>	<b>39,576,906.51</b>
210401	Бичиг хэрэг	2,873,320.00	4,273,811.50
210402	Тээвэр, шатахуун	19,455,689.99	26,953,491.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,865,000.00	1,782,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	295,000.00	493,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	718,350.00	6,074,104.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,096,000.00</b>	<b>7,488,150.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,012,850.00
210604	Урсгал засвар	5,096,000.00	5,475,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,352,600.00</b>	<b>5,234,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,352,600.00	5,234,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,276,578.00</b>	<b>1,291,298.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	443,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	358,200.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,971.00	149,298.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	306,950.00	303,500.00
210807	Газрын төлбөр	43,657.00	50,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>123,443,591.90</b>	<b>215,810,149.06</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,674,313.00	46,987,435.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	140,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,769,278.90	168,682,714.06
210904	Найдваргүй авлагын алдагдал	0.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,865,243.69</b>	<b>45,836,947.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,933,300.00</b>	<b>19,533,850.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,413,300.00	18,315,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,520,000.00	1,218,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>28,931,943.69</b>	<b>26,303,097.43</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>81,874,771.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>81,874,771.00</b>	<b>0.00</b>
223001	Бусад хөрөнгө	81,874,771.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>167,342,594.61</b>	<b>102,592,710.61</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>117,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	117,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0.00</b>	<b>(117,000.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>167,342,594.61</b>	<b>102,475,710.61</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>291,187,761.00</u></b>	<b><u>493,735,073.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,280,000.00</b>	<b>4,815,535.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>4,815,535.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>00.00</b>	<b>4,815,535.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,815,535.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>2,280,000.00</b>	<b>00.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	2,280,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>288,907,761.00</b>	<b>488,919,538.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>64,106,861.00</b>	<b>44,545,538.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,106,861.00	44,545,538.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>224,800,900.00</b>	<b>444,374,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,800,900.00	444,374,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>192,153,626.75</u></b>	<b><u>451,449,535.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>192,153,626.75</b>	<b>451,449,535.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>192,093,626.75</b>	<b>405,852,137.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>132,464,671.95</b>	<b>242,756,177.97</b>
210101	Үндсэн цалин	115,160,001.96	196,552,121.89
210102	Нэмэгдэл	00.00	33,322,804.68
210104	Урамшуулал	00.00	11,201,251.40
210105	Гэрээт ажлын хөлс	17,304,669.99	1,680,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,018,719.10</b>	<b>30,336,377.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,602,539.78	20,654,440.47
210202	Тэтгэмжийн даатгал	1,354,044.90	2,429,934.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,083,235.69	1,933,867.24
210204	Ажилгүйдлийн даатгал	270,809.11	483,466.92
210205	Эрүүл мэндийн даатгал	2,708,089.62	4,834,668.31
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,613,873.70</b>	<b>37,171,049.38</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,132,493.70	3,673,481.38
210302	Түлш, халаалт	13,481,380.00	33,497,568.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,260,600.00</b>	<b>24,268,800.00</b>
210401	Бичиг хэрэг	846,400.00	2,307,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,608,800.00	17,774,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,200.00	1,782,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	155,200.00	1,704,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>440,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	440,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,850,600.00</b>	<b>7,935,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,700,000.00	4,819,900.00
210602	Тавилга	00.00	424,000.00

210604	Урсгал засвар	1,150,600.00	2,691,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	800,000.00	2,988,900.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	2,988,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>939,998.00</b>	<b>1,291,298.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	443,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,971.00	149,298.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	214,370.00	303,500.00
210807	Газрын төлбөр	43,657.00	50,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,145,164.00</b>	<b>58,664,235.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,755,164.00	55,247,735.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	390,000.00	3,416,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>60,000.00</b>	<b>45,597,397.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	60,000.00	19,294,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	2,557,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	26,303,097.43
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>99,034,134.25</u></b>	<b><u>42,285,538.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>63,380,197.00</b>	<b>42,285,538.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>63,380,197.00</b>	<b>42,285,538.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	63,380,197.00	42,285,538.00
223001	Бусад хөрөнгө	63,380,197.00	42,285,538.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	99,034,134.25	42,285,538.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	35,653,937.25	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	466,148,746.99	226,684,531.40	-50,523,170.69	00.00	642,310,107.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>466,148,746.99</b>	<b>226,684,531.40</b>	<b>-50,523,170.69</b>	<b>00.00</b>	642,310,107.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	167,342,594.61	00.00	167,342,594.61
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>470,247,326.99</b>	<b>254,696,274.65</b>	<b>152,632,648.81</b>	<b>00.00</b>	877,576,250.45
D01	<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>470,247,326.99</b>	<b>254,696,274.65</b>	<b>152,632,648.81</b>	<b>00.00</b>	877,576,250.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>470,247,326.99</b>	<b>254,696,274.65</b>	<b>152,632,648.81</b>	<b>00.00</b>	877,576,250.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	102,475,710.61	00.00	102,475,710.61
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>470,247,326.99</b>	<b>254,696,274.65</b>	<b>255,108,359.42</b>	<b>00.00</b>	980,051,961.06

**Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>444,374,000.00</b>	<b>418,070,902.57</b>	<b>26,303,097.43</b>	94.08
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>444,374,000.00</b>	<b>418,070,902.57</b>	<b>26,303,097.43</b>	94.08
Бараа, үйлчилгээний зардал	<b>425,603,700.00</b>	<b>399,321,602.57</b>	<b>26,282,097.43</b>	93.82
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<b>260,460,600.00</b>	<b>242,756,177.97</b>	<b>17,704,422.03</b>	93.20
Үндсэн цалин	240,300,600.00	196,552,121.89	43,748,478.11	81.79
Нэмэгдэл	-	33,322,804.68	(33,322,804.68)	
Урамшуулал	-	11,201,251.40	(11,201,251.40)	
Гэрээт ажлын хөлс	20,160,000.00	1,680,000.00	18,480,000.00	8.33
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<b>32,557,600.00</b>	<b>30,336,377.22</b>	<b>2,221,222.78</b>	93.18
Тэтгэврийн даатгал	22,139,100.00	20,654,440.47	1,484,659.53	93.29
Тэтгэмжийн даатгал	2,604,600.00	2,429,934.28	174,665.72	93.29
ҮОМШӨ ний даатгал	2,083,700.00	1,933,867.24	149,832.76	92.81
Ажилгүйдлийн даатгал	521,000.00	483,466.92	37,533.08	92.80
Эрүүл мэндийн даатгал	5,209,200.00	4,834,668.31	374,531.69	92.81
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	<b>37,193,700.00</b>	<b>37,171,049.38</b>	<b>22,650.62</b>	99.94
Гэрэл цахилгаан	6,542,300.00	3,673,481.38	2,868,818.62	56.15
Түлш, халаалт	30,651,400.00	33,497,568.00	(2,846,168.00)	109.29
Хангамж, бараа материалын зардал	<b>20,699,000.00</b>	<b>20,699,000.00</b>	-	100.00
Бичиг хэрэг	1,186,100.00	1,120,100.00	66,000.00	94.44
Тээвэр (шатахуун)	15,890,800.00	16,652,400.00	(761,600.00)	104.79
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,385,600.00	1,650,000.00	735,600.00	69.16
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	536,500.00	576,500.00	(40,000.00)	107.46
Нормативт зардал	<b>441,500.00</b>	<b>440,000.00</b>	<b>1,500.00</b>	99.66
Нормын хувцас зөөлөн эдлэл	441,500.00	440,000.00	1,500.00	99.66
Эд хогшил худалдан авах	<b>13,102,400.00</b>	<b>6,846,300.00</b>	<b>6,256,100.00</b>	52.25
Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00	4,819,900.00	2,680,100.00	64.27
Тавилга	4,000,000.00	424,000.00	3,576,000.00	10.60
Урсгал засвар	1,602,400.00	1,602,400.00	-	100.00
Томилолт, зочны зардал	<b>2,824,900.00</b>	<b>2,820,900.00</b>	<b>4,000.00</b>	99.86
Дотоод албан томилолт	2,824,900.00	2,820,900.00	4,000.00	99.86
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	<b>1,363,500.00</b>	<b>1,291,298.00</b>	<b>72,202.00</b>	94.70
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	443,700.00	6,300.00	98.60
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	160,000.00	160,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	120,000.00	118,800.00	1,200.00	99.00
Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	149,298.00	50,702.00	74.65
Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	66,000.00	14,000.00	82.50
Мэдээллийн технологийн зардал	303,500.00	303,500.00	-	100.00
Газрын төлбөр	50,000.00	50,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	<b>56,960,500.00</b>	<b>56,960,500.00</b>	-	100.00

Бараа үйлчилгээний бусад зардал	53,544,000.00	53,544,000.00	-	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,416,500.00	3,416,500.00	-	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,770,300.00</b>	<b>18,749,300.00</b>	<b>21,000.00</b>	99.89
Бусад урсгал шилжүүлэг	18,770,300.00	18,749,300.00	<b>21,000.00</b>	99.89
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	16,737,300.00	16,737,300.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,033,000.00	2,012,000.00	<b>21,000.00</b>	98.97
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>444,374,000.00</b>	<b>418,070,902.57</b>	<b>26,303,097.43</b>	94.08
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>444,374,000.00</b>	<b>418,070,902.57</b>	<b>26,303,097.43</b>	94.08
Орон нутгийн төсвөөс	444,374,000.00	418,070,902.57	<b>26,303,097.43</b>	94.08
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	<b>(0.00)</b>	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	<b>(0.00)</b>	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	25	25	-	100.00
Удирдах ажилтан	7	7	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.00
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.00
Гэрээт ажилтан	5	5	-	100.00
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/</b>	-	-	-	-
<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>49,361,073.00</b>		
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>7,075,535.00</b>		
Бараа, үйлчилгээний зардал		<b>6,530,535.00</b>		
Хангамж, бараа материалын зардал		3,569,800.00		
Бичиг хэрэг		1,187,800.00		
Тээвэр (шатахуун)		1,122,000.00		
Шуудан холбоо, интернэтийн төлбөр		132,000.00		
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		1,128,000.00		
Эд хогшил худалдан авах		<b>1,089,000.00</b>		
Урсгал засвар		1,089,000.00		
Томилолт, зочны зардал		<b>168,000.00</b>		
Дотоод албан томилот		168,000.00		
Бараа үйлчилгээний бусад зардал		<b>1,703,735.00</b>		
Бараа үйлчилгээний бусад зардал		1,703,735.00		
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		545,000.00		
Бусад урсгал шилжүүлэг		545,000.00		
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		545,000.00		
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>42,285,538.00</b>		
Дотоод эх үүсвэрээр		42,285,538.00		
Бусад хөрөнгө		42,285,538.00		
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>49,361,073.00</b>		
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		4,815,535.00		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,815,535.00		

Нэмэлт санхүүжилтийн орлого		44,545,538.00		
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		44,545,538.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузаль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,475,7 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	0.6	0.6
Бараа материал	48,832.8	44,261.4	4,571.4
Үндсэн хөрөнгө	828,743.4	935,789.8	107,046.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>877,576.2</b>	<b>980,051.9</b>	<b>102,475.7</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	877,576.2	980,051.9	102,475.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>877,576.2</b>	<b>980,051.9</b>	<b>102,475.7</b>

Бараа материал дансны үлдэгдэл 44,261.4 мянган төгрөг болж 4,571.4 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг 201.9 мянга, аж ахуйн материал 4,330.1 мянга, сэлбэг хэрэгсэл 200.0 мянга, түлш, шатах тослох материал 2,016.2 мянга, бусад хангамжийн материал 1,820.5 мянган төгрөгөөр буурч, мал, амьтан 3,997.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 935,789.8 мянган төгрөг болж 107,046.4 мянган төгрөгөөр өссөнд барилга байгууламж 74,799.9 мянга, авто тээврийн хэрэгсэл 43,600.0 мянга, тоног төхөөрөмж 28,425.6 мянга, тавилга хэрэгсэл 500.0 мянга, бусад үндсэн хөрөнгө 128,520.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, авто тээврийн хэрэгсэл 10,995.0 мянга, үндсэн хөрөнгө худалдсаны гарз 117.0 мянга, 168,682.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 444,374.0 мянган төгрөг, нийт зарлагыг 444,374.0

мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 444,374.0 мянган төгрөгөөр бууруулж 444,374.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 444,374.0 мянга, нийт 444,374.0 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр төсвийн нийт зардлын гүйцэтгэл 418,070.9 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь үндсэн данснаас хэмнэгдсэн байна. Үндсэн данснаас 26,303.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн төсвөөс	444,374.0	418,070.9	26,303.1	94.08%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 44,545.5 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,815.5 мянга, нийт 49,361.1 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 3,569.8 мянга, эд хогшил худалдан авах зардалд 1,089.0.0 мянга, томилолтын зардалд 168.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,703.7 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 545.0 мянга, Бирвазны сайжруулалтад 42,285.5 мянга, нийт 49,361.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батсуурь гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5,782.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 625,501.0 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 6,255.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,004.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Завхан сумын Засаг даргын тамгын газрын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан мэдээлэл 7, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Завхан сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Завхан сумын Засаг даргын тамгын газрын дарга Т.Тамир нь 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Завхан сумын Засаг даргын Б/04 тоот захирамжаар чөлөөлөгдөж Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзэн ажилд нь эргүүлэн томилж ажиллаагүй хугацааны цалинг олгож нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн бичих шийдвэр гаргасан байна. Шүүхийн шийдвэрийн дагуу Завхан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/14 тоот тушаалаар ажилд эргүүлэн томилсон байна. 2022 онд ажиллаагүй хугацааны цалинд 13,763.3 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж төрийг хохиролгүй болгуулах асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь хэсэгт заасны дагуу Санхүү хяналт дотоод аудитын албанд албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг ирүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд “Шинэ хөдөө Увс” төслийн шугамаар ирсэн “Сэлэнгийн халзан-Герефорд” үүлдрийн 3,997.3 мянган төгрөгийн 1 ширхэг өсвөр насны бухыг мал амьтад дансанд бүртгэсэн байна. Тухайн мал амьтныг гэрээ байгуулан иргэдэд эзэмшүүлж байх бөгөөд дараагийн аудитын хүрээнд ашиглалт, гэрээний үр дүнг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар 232.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож хүргүүллээ.

#### **5.1 Төлбөрийн акт**

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын

1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, **зочин төлөөлөгч хүлээн авах**, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, Засгийн газрын Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчин нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээ мониторингийн ажлын хэсэг ирж ажиллахад хоолны зардалд 232000 төгрөгийг зарцуулж төрд хохирол учруулсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр 232,000 төгрөгөөр нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалын зардлаас хоолны үнэ төлсөн	1	232.0	1	232.0								
Дүн	1	232.0	1	232.0								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /С.БАТСУУРЫ/

2023 оны 02 дугаар сарын 23-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/17/A2070660

Улаангом

УВА-2023/60/НА-СГА-ТМБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Завхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээ мониторингийн ажлын хэсэг ирж ажиллахад хоолны зардалд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 232,000 төгрөгийн гаргаж төрд хохирол учруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх заалтад "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, **зочин төлөөлөгч хүлээн авах**, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", Засгийн газрын Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын

4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээ мониторингийн ажлын хэсэг ирж ажиллахад зарцуулсан хоолны үнэ 232000 /хоёр зуун гучин хоёр мянга/ төгрөгийг Завхан сумын Засаг даргын тамгын газрын дарга Т.Тамираар төлүүлж Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Завхан сумын Засаг дарга А.Ягаан, нягтлан бодогч Б.Гантуяа нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ